



ЭКО АСФАЛЬТ

## “ЭКО АСФАЛЬТ” ХХК

ЗАМ БАРИЛГА, БЕТОН ЭДЛЭЛ, АСФАЛЬТБЕТОН  
ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,

3-р хороо, ТЭЦ-3 баруун талд

Утас: 99115898, 94115020

И-мэйл: eco.asphalt99@gmail.com

2022.12.20 № 70/22  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН  
БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗАР”-Т

Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Манай “Эко асфальт” ХХК нь авто замын материал үйлдвэрлэлийн чиглэлээр Хан-Уул дүүргийн 3-р хороо нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Асфальтбетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүргүүлж байгааг хүлээн авна уу.

ЗАХИРАЛ



Д.БАТБОЛД



**“ЭКО АСФАЛЬТ” ХХК**

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛЬТБЕТОН ХОЛЬЦЫН  
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2023**

БАТЛАВ:

БОАЖЯ,ХБОБНУГазрын дарга

Ц. УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:  
“ЭКО АСФАЛЬТ”ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Д.БАТБОЛД

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛЬТБЕТОН ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР”ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Регистрийн дугаар: 6001769

ХҮЛЭЭН АВЧ, ХАЯНАСАН:  
ХБОБНУГазрын мэргэжилтэн

П.ШИНЭЦЭЦЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
МАТЕРИАЛЫН ИНЖЕНЕР

Г. МЯГМАРЖАВ

УЛААНБААТАР ХОТ 2023

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Агуулга

ОРШИЛ.....	2
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн нэр : “Асфальто бетон хольцын үйлдвэр” төсөл.....	4
1.2. Төслийн байршил.....	4
1.3. Танилцуулга.....	4
1.4. Төслийн хүчин чадал.....	5
1.5. Төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал.....	6
1.6. Дэд бүтэц.....	6
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	9
2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	13
3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн төлөвлөгөө.....	15
4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	16
5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	19
8. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	20
Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь ...	21
ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	22

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛЬТ БЕТОН ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ОРШИЛ**

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго**

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Асфальто бетон хольцын үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад зорилго оршино.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан төлөвлөгөөг ойлгоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газар, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн бол сумын Засаг даргад хүргүүлэн хянуулж батлуулна.

Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага болон сумын Засаг дарга хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн бичиг баримт болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОННУ-ний тайланг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга хэсгүүд баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана.

Төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа нь зах зээл, эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт үзэгдэл, тухайн бүс нутаг, хүн амыг хамарсан халдварт өвчин, тахал зэрэг давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас зогсонги байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 1 сарын дотор хандан, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулах хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй талаарх тодорхойлолтыг төсөл хэрэгжиж буй сум, дүүргийн Засаг дарга хэд хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн хувьд аймаг, нийслэлийн байгаль орчны газар тодорхойлсон байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү журамд заасан шаардлагыг хангаж боловсруулаагүй бол түүнийг хүлээн авч хянах, батлахаас татгалзах үндэслэл болно.

Ашигт малтмал ашиглах, хайх, дэд бүтцийн барилга байгууламж барих зэрэг улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тэдгээрийн тухайн оны төлөвлөлттэй уялдуулан эхний улиралд багтаан хянаж, эцэслэн батална.

Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**1.1. Төслийн нэр : “Асфальт бетон хольцын үйлдвэр” төсөл**

**Төсөл хэрэгжүүлэгч:**

Хувийн хөрөнгө оруулалттай “ЭКО АСФАЛТ” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011571011  
Регистрийн дугаар: 6001769 Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний  
дугаар: 0232523 -10000м<sup>2</sup> “ Би Ти ӨҮ” ХХК-ийн газрыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж  
байна.

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороо ТЭЦ-3-ын баруун урд талд байрладаг. Харилцах  
утас: Захирал: Д. Батболд 99115898

**1.2. Төслийн байршил**

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт 3 р хороонд байрлах ба Яармагийн гүүрнээс баруун хойно 400  
метрт өөрөөр хэлбэл 3-р ДЦС -ын баруун урд талд 350 метр зайд туслах замын хажууд 10000 м<sup>2</sup>  
талбайд байрлана.

Хүснэгт 1.Төслийн байршилын координат

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	51	29,39	47	53	28,36
2	106	51	28,86	47	53	28,88
3	106	51	27,49	47	53	30,20
4	106	51	31,42	47	53	32,12
5	106	51	34,94	47	53	28,66



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн google earth-н зураг

**1.3. Танилцуулга**

Эко асфальт ХХК нь 2015 онд байгуулагдсан хувийн өмчтэй 2 гишүүнтэй авто зам барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Нийслэлийн засаг даргын 2011 оны 12-р сарын 908 тоот шийдвэртэй 0232523 дугаартай эзэмшлийн гэрчилгээтэй 10000м<sup>2</sup> “ Би Ти ӨҮ” ХХК-ийн газрыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна. “Эко асфальт” ХХК-ийн асфальтобетон хольцын үйлдвэр нь Хятад улсад үйлдвэрлэгдсэн LB 120 маркийн байгаль орчинд

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

хор нөлөөгүй, усан филтэртэй, эко үйлдвэр суурилуулсан болно. Үйлдвэрийн бүтээгдэхүүн нь Монгол улсын MNS 1592:2009 стандарт техникийн шаардлагыг хангасан болно. Тус үйлдвэр нь жилдээ 15000тн асфальтыг үйлдвэрлэдэг ба 13 хүнийг ажлын байраар хангана.

**1.4. Төслийн хүчин чадал:**

**Асфальтобетон зуурмагын үйлдвэрийн хүчин чадал:**

Тус асфальтобетон хольцийн үйлдвэр нь БНХАУ-ын LONGLI MECHANICAL ХХК-д үйлдвэрлэсэн LB-1200 маркийн бүрэн автомат тоног төхөөрөмжтэй бөгөөд энэ цагт 120 тн асфальт гаргах хүчин чадалтай юм.

Асфальтобетон нь битум болон жижиг том дүүргэгч эрдэс нунтагийг тогтсон харьцаагаар хийж нэг төрлийн болтол хольж зуурсаны дараа тэр нь бэхжих процесс эхлэх хүртэл өөрийн хөдөлгөөнт чанараа хадгалж байгаа асфальт бетон хольц юм.

Асфальтобетон хольцын түүхий эд болох битумыг дотоодын зах зээлээс худалдан авдаг ба шингэн битумыг хадгалах тус бүрдээ 50 тн даацтай 9 ширхэг савыг үйлдвэрийн дэргэд газар доор суурилуулсан. Мөн хайрга, элсийг дотоодын зах зээлээс худалдаж авч ашигладаг. Асфальтобетон хольцод ашиглах дүүргэгч дайрга нь MNS 0390:1998, элс нь MNS 0392:2014, барьцалдуулагч битум нь MNS 6237:2010, MNS 5230:2002, эрдэс нунтаг нь MNS 4904-1:2000 стандарт техникийн нөхцөл шаардлагыг хангасан байна.

Хүснэгт. 1 Асфальтобетоны орц ба үйлдвэрт бэлтгэж зуурч гаргаж байгаа хольцын ерөнхий техникийн үзүүлэлтийг доор харуулав.

Д/Д	Материал	Хувиар /%/	Нэг зууралтанд 1000 кг	Нийлүүлэгч компани
1	Дайрга /10-20мм/	10,0	100	“Цээцээ Импекс” ХХК
2	Дайрга /5-10мм/	35,0	350	“Цээцээ Импекс” ХХК
3	Элс /0-5/	48,0	480	“Цээцээ Импекс” ХХК
4	Эрдэс нунтаг	7,0	70	“ТЭВХЭН” ХХК
5	Битум БНД90/130	5,5	55	“Монголбитум индустрал” ХХК

Асфальтобетон хольц бүрдүүлэгч материалууд нь түүний чанарт янз бүрээр нөлөөлдөг тухайлбал: дайрга, /хайрга/ нь хучилтын бат бэх, хөшүүн байдлыг хангаад зогсохгүй авто замаар өнгөрөх тээврийн хэрэгслэлүүдийн үйлчилгээн доорх эсэргүүцлийг сайжруулах гол араг яс, их бие нь болдог бол элс нь хольцын томоохон нүх сүв зайнуудыг дүүргэж хольцыг илүү уян хатан болгодог байна. Асфальтобетон хольцын бат бэх нь түүнд эрдэс нунтаг оруулсанаар хангагдана.

Эрдэс нунтаг нь битумтэй хамт наалдамтгай материал болж хольцын эрдсийн хэсгүүдийн хоорондох барьцалдалгааг хангаж хүчитгэн улмаар хучилтын цул байдлыг бий болгож түүний механик бат бэх, дулаанд тогтвортой чанарыг дээшлүүлнэ.

Битумын хувьд түүний гол шинж чанар нь зууралдмал, уян хатан наалдуулах чанарт орших бөгөөд энэ материал нь ус болон халуун хүйтний үйлчилгээний эсрэг тогтвортой, тодорхой хэсэг хугацааны дотор уян хатан байдлаа хадгалаж чаддаг чанартай юм.

Иймээс битумын наалдуулах чадварыг нэмэгдүүлэхийн тулд мөн чулуун материалын гадаргууг зөвхөн бүрээд зогсохгүй түүнд улам сайн шингээх зорилгоор аль аль материалуудыг тогтоосон хэмжээнд нь хүртэл заавал халаах ёстой байдаг.

Халаах процессыг 3-р “ДЦС” - тай хийсэн “Уурын Дулаан Эрчим Хүч Худалдах Худалдан Авах” гэрээний дагуу стандарт шаардлагыг хангасан халуун уураар хангана.

Дулааны горим ёсоор хайрга, /дайрга/ элсэн материалыг 180<sup>0</sup> хүртэл, битумыг төрөл маркаас нь хамааруулан өтгөн битумыг 140-170<sup>0</sup>, шингэн битумыг 70-100<sup>0</sup> хүртэл тус тус халаана. Хэт хүйтэн эрдэс нунтаг хэрэглэх тохилдолд хайрга / дайрга/ , элсийг халаах температурыг 200-220<sup>0</sup> –д хүргэдэг.



**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт. 2 Асфальтобетонд орох битумын марк, үйлдвэрээс гарах, замд дэвсэх үеийн хольцын температур зэрэг нь дараах хүснэгтийн дагуу байвал зохино.

Хольцын төрөл	Битумын марк	Хольцын доошгүй байх температур	
		Холигчоос гарах үед	Замд дэвсэх үед
Халуун	БнД 40/60 БнД 60/90 БнД 90/130	140-160	120

Хэрэв идэвхжүүлсэн эрдэс нунтаг хэрэглэсэн тохиолдолд халуун хольцны энэ температурыг 20° С-аар багасгаж харин дэвсэх үеийн температур нь 5-аас бага байвал хүснэгтийн температурыг 10° С-аар нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Өтгөн битумын хувьд манай нөхцөлд БнД 60/90, БнД 90/130марк нь илүү тохиромжтой байдаг байна.

Асфальтобетоны үндсэн түүхий эд болох БнД90/130”маркын битумыг “Евробитум” ХХК-иас баталгаажсан шинжилгээний бичигтэйгээр нийлүүлдэг. Мөн эрдэс нунтагийг “Тэвхэн” ХХК -иас баталгаажсан шинжилгээний бичигтэй нийлүүлдэг.

**1.5. Төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал**

**Газарзүй :** Улаанбаатар хот нь Хатан Туулын хөвөөнд, Хан Богдын хормойд Монгол улсын төвийн бүсэд, далайн түвшнээс 1350 м-т оршдог, 470 000 га нутаг дэвсгэртэй.

Богд Хан Уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн гол мөрөн, түүний бусад салбар уулсаас бүрдэнэ.Богд Хан уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268 м өргөгдсөн Цэцээ гүн болно.


Улаанбаатар хот түүний орчим нутаг нь Хангай, Хэнтийн атираат бүсийн Хэнтийн бүсийн баруун өмнөд талд оршино. Богд Хан уул нь Хэнтийн ай савд багтах гол нуруунаас салангид орших бөгөөд өндрийн далан уулархаг хотгор гүдгэрийн нөлөөгөөр ой тайгын ландшафт голлох ба манай орны ойн тархалтын хамгийн өмнөд зах нь болно.

**Уур амьсгал**

Төслийн объект нийслэлийн Хан-уул дүүрэг, Үйлдвэрийн гудамж 2-т Туул голын дэнж дээр байрлана. Төслийн объектийн оршиж байгаа үйлдвэрийн районд цаг уурын ажиглалтын цэг байхгүй учир энэхүү тодорхойлолтыг Туул голын хөндийд орших буянт ухаа цаг уурын өртөөний олон жилийн ажиглалтын мэдээг голчлон баримталж бичсэн болно. Энэ нь төслийн объект болон Буянт ухаа цаг уурын өртөөний далайн түвшнээс дээшхи өндөр ойролцоо, хэдхэн метрийн зөрөөтэй, хоёулаа голын хөндийд оршиж байгаа байдал ижил төстэй тал болж өгнө.

**1.6. Дэд бүтэц**

**Цахилгаан хангамж:** Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах Эко Асфальт ХХК-ийн асфальтобетоны хольцын үйлдвэрийн бүс нь цахилгаан эрчим хүчний төвлөрсөнсүлжээнд холбогдсон ба үйлдвэрийн хашаандаа өндөр хүчдэлийн үүсгүүртэй.



УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зураг 2. Өндөр хүчдэлийн үүсгүүр

**Усан хангамж:** Үйлдвэрийн усаа төвийн шугамнаас татан авч хэрэглэдэг. Унд ахуйн усаа зөөврөөр ажигладаг.

**Харилцаа холбоо:** Уг үйлдвэр нь дэд бүтцийн хөгжил сайтай газар байрладаг тул харилцаа холбоо чөлөөтэй.

**Хог хаягдал:**

Шингэн хог хаягдал – Үйлдвэрийн хувьд шингэн хог хаягдал нь асфальт үйлдвэрлэх процессын үед гарах хийн хаягдалыг усан хөшигнөөс буух шингэн хаягдлаа газрын гадаргаас доош ухсан 2м гүн 10х6 метр хатуу гадаргуутай бункерт хуримтлуулан дүүрмэгц Далив ХХК-тай байгуулсан гэрээний дагуу соруулан авна.

Хатуу хог хаягдал – Үйлдвэрийн процесс нь хайргаа +165<sup>0</sup> хүртэл халаах хэрэгтэй байдаг ба үйлдвэрийн зарим процессд доголдол гарснаар хүрэх ёстой температурт хүрээгүй хайрга нь үйлдвэрийн хатуу хог хаягдалд тооцогдоно. Гэхдээ үйлдвэрийн хашаанд хатуу хог хаягдал болох хайргыг хатуу хучилт болгон дахин ашиглаж байгаа.

Мөн ажилчдын унд ахуйн хэрэглээнээс ахуйн хог хаягдал багагүй ялгарах ба эдгээр хог хаягдалыг Хан-Уул дүүргийн ТҮК- тэй гэрээ байгуулан ачиж тээвэрлэнэ. Уг үйлдвэр нь 13 ажилчинтай: нэг хүн 0,3 кг хог хаягдал гаргана гэж үзвэл  $13 \times 0,3 \text{ кг} = 3,9 \text{ кг}$  хаягдал өдөрт гарах ба сард  $30 \times 3,9 = 117 \text{ кг}$  ахуйн хог хаягдал гарахаар тооцлоо.

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг БОАЖ сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, гөзрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Аймаг нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Улирлын чанартай ажилладаг уурхайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг талбай дээр бодитоор нь үнэлэх, хэмжилт хийх боломжтой нөхцөлд зохион байгуулна.

**Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр:** Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Агаартай холбоотой хуулийн нэр томъёоны тайлбар. Үүнд:

- “Хүрээлэн байгаа агаар” гэж байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн нэг болох хийн мандлын байгалийн төлвөөрөө байгаа хийн хольцыг хэлнэ.
- “Агаарын бохирдол” гэж хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсэж бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг;
- “агаарын чанар” гэж агаарын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанарыг;
- “агаарын чанарын хяналт-шинжилгээ” гэж агаарын чанарын төлөв байдал, түүний өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж үнэлэх үйл ажиллагааг;
- “Агаарын чанарыг сайжруулах бүс” гэж агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тусгай дэглэм тогтоож, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хилийн зааг бүхий нутаг дэвсгэрийг;
- “агаар бохирдуулах бодис” гэж бохирдлын аливаа эх үүсвэр, эсхүл түүнээс хаягдаж хүрээлэн байгаа агаар бохирдуулж байгаа физик, хими, биологийн болон цацраг идэвхт бодис, тэдгээрийн хольцыг;
- “аюултай бохирдуулах бодис” гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бохирдуулах бодисыг;

**Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:**

- Асфальтобетон үйлдвэрлэлийн үед агаар орчинд маш PM2.5, PM10 бүхий тоос үүсэх бөгөөд үүнийг бууруулахын тулд задгай талбайг өглөө үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө услаж, чийгтэй байлгах арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн тээвэрлэлт хийх талбайг бүхэлд нь хатуу хучилттай болгох
- Бүтээгдэхүүн ачих зөөх, дамжуулах, түүхий эд болох элс хайрга буулгах, цемент зөөх, дамжуулах, зуурмаг зуурах хийх цаг хугацааг тухайн үеийн салхины чиглэл, хурдтай уялдуулж зохицуулна. Мөн гарах тоос, тоосонцор шороог багасгах үүднээс усалгааг өглөөд тогтмол хийж байх. Салхины чиглэл, цаг хугацааг сонгож авахдаа үйлдвэрлэлийн аливаа объектгүй чиглэлд байхаар зохицуулах нь хүмүүс, объектыг шорооноос хамгаалах, түүний сөрөг нөлөөллийг бууруулахад дөхөм үзүүлэх нэг арга болно. Мөн үйлдвэр орчмын тээврийн зам болон ачих, буулгах үеийн хөрс шороог байнга чийглэж норгох үйл ажиллагаа явуулна.
- Машин механизмын утаат яндангаас ялгарах хорт хийн агууламжийг бууруулах зорилгоор утааны янданг тусгай шүүлтүүрээр /76mm Air Intake Air Filter Car Truck/ тоноглохын зэрэгцээ техникийн оношлогоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх.
- Мөн агаарт тархах тоосны хэмжээг багасгах зорилгоор гаднах талбайн 10 хувьд ногоон байгууламж байгуулж цэцэгийн мандал тарих.
- Халцарсан газрыг байнга нөхөн сэргээж байх.
- Ашиглаж буй зам, түүний орчныг хайрган хучилттай болгох, байгалийн ургамлын байнга ургах нөхцөлийг бүрдүүлэх.
- 1 тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд оролцож мод тарих.

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Компаний нийгмийн хариуцалгын хүрээнд сайн үйлсийн аянд Хан-Уул дүүрэгтэй хамтарч ажиллах.

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ "АСФАЛЬТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрийн яндангаас гарах утаа	Үйлдвэрийн халаах процессын үед үүсэх утаанд химийн найрлагын шинжилгээ хийлгэх, утааг багасгах техникт өөрчлөлт оруулах /сэлбэх/	Төслийн хүрээнд	300.0	2023	MNS3113:1981 "Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага" MNS3384:1982 "Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ" MNS ISO4227-2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS4585-2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS5885-2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS6063-2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ" MNS4990-2000 "ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага". MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
Тоног төхөөрөмжийн ажиллах үед ялгарах илүүдэл хаягдал	Усан яндангаас үүсэх хаягдал шингэн болон илүүдэл лагийг ууршиж орчин бохирдуулахаас өмнө зайлуулдаг Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглах авто машинуудын янданд /76mm Air Intake Air Filter Car Truck/ утаа шүүх шүүлтүүр суурьлуулах, солиулж байх	Үйлдвэрийн хүрээнд	1.000.0	2023	
Түүхий эд буулгах үед гарах PM-2,5 PM-10 тоосонцор Үүсэх	Түүхий эд буулгах үед гарах тоосонцорын дараа талбайд усалгаа хийх. Мөн PM-2,5 PM-10 тоосонцорын шинжилгээ өгөх	Үйлдвэрийн хүрээнд	400.0	2023	
			100.0	2023	

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ "АСФАЛЬТ БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<p>Үйлдвэрийн орчмын агаарын чанар стандартаас хэлэрсэн</p>	<p>Үйл ажиллагаа явуулж байгаа талбайг хайрган хучилттай болгох</p>	<p>Үйлдвэрийн хүрээнд</p>	<p>Түрүү жил нөөцөлсөн</p>	<p>2023</p>	
<p><b>Нийт дүн</b></p>			<p><b>1.800 000</b></p>		

**2.Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

- Төслийн үйл ажиллагааны явцад үүссэн газрын гадаргын эвдрэлд өртсөн хэсгүүдэд ажлын явцад төрх байдлын сайжруулалт хийж, ухмал нүх овоолгыг тэгшилж байх
- Төслийн талбайд хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд болон тухайн орчиндоо сөрөг нөлөөллийг бий болгох газар ашиглалтыг төлөвлөхгүй байх
- Төслийн явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, зам тавих, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөнд оруулдаг ч орчны тохижилт, ногоон байгууламжийг зохистой байршуулж асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Төслийн талбайн орчимд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулахдаа зориулалтын хогийн цэг байгуулан асгаж байх шаардлагатай.
- Төслийн явцад хөрсийг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдалаар бохирдуулахгүй байх
- Үйлдвэрт ашиглагдах барилга байгууламжийг барьж байгуулахдаа урьдаас сайтар төлөвлөж, орчныхоо байгаль, цаг уурын нөхцөл байдалтай (салхины зонхилох зүг чиг, гадаргын хэвлий, нарны цацрагийн шууд тусгал гэх мэт) сайтар уялдуулан тооцоолох
- Үйлдвэрийн үндсэн ба туслах байгууламжуудыг барих явцад болон хүнд машин механизмын холхилтоор эвдэрсэн хөрс, газрыг дор бүр нь засаж сэргээж байх
- Газрын гадаргын эвдрэл доройтлын төлөв байдлын судалгаа, хөрсний чанарын хяналт баталгааг жил тутамд хийлгэж байх



УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДУУРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТ БЕТОН ХОЛЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.Газрын гадарга, хөрсөн бүрхэвч

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрлэлийн ажиллагааны явцад орчны хөрсний физик-механик бүтцэд өөрчлөлт орж элэгдэл болон эвдрэл үүсэх	Хөрсөнд шагах тослох материал асгарч бохирдохоос урьдчилан сэргийлэх /орж гарах машинд мөн өөрсдийн машин механизмд хяналт тавьж, сэлбэг сольж байх/ Үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдэхүүнийг ачих, зөөх ажлын үед олон салаа зам гаргаж, хөрсний элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулахаас урьдчилан сэргийлэх /тусгайлан хайрган хучилттай зам болдох/	Үйл ажиллагаа явуулж буй талбайд	200,0	2023	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан багалгаа хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан багалгааг хийлгэх, MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техниккийн шаардлага”, MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техниккийн шаардлага” MNS5850-2008 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Шагах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асаргалтаас хөрс бохирдох, Технологийн горимыг зөрчих, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх,	Хөрсний эвдрэлээс тоосжилт үүсэх, хөрсний эвдрэл үүсэх зэрэг болзошгүй ослоос хамгаалж зөвхөн зориулалтын замаар зорчуулж цэвэрлэгээг тогтмол хийлгэх Агуулах сав (резервуар), далд шугам хоолойн шүүрэлт, Гоожилтыг хянах автомат систем нэвтрүүлсэнээ жил болгон сайжруулж байх		Үйл ажиллагааны зардал тусгах 450,0	2023	
Үйлдвэр болон ахуйн гэрэлтэй хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох.	Хог хаягдал тухайн төслийн талбайд ил задгай хаясан хог тархах болон байгаль орчин бохирдуулахаас хамгаалах, цэвэрлэгээг тогтмол хийх		150,0	2023	
<b>Нийт дүн</b>			<b>800,000</b>		

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТО БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арилгах арга хэмжээ	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрлэлийн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	Технологийн хаягдал ус - аас мэргэжлийн байгууллагаар хяналтын дээж авахуулан шинжилгээ хийлгэх (жилд 2 удаа)	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Үйлдвэрийн орчимд	150,0	2023	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль - “Үйлдвэрлэлийн технологийн хаягдал ус, Усны чанар, Техникийн ерөнхий шаардлага.” - MNS 6148:2010. Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, Бохир ус, хаягдал усны стандарт MNS 4943:2015
Үйлдвэрээс гарах бохир ус, хагуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийдэггүйгээс газрын доорх ус бохирдох, горимыг алдагдуулах;	-Ус бохирдуулсаны төлбөрийг харъяа дүүрэгт жил тутам төлөх, -үйлдвэрээс гарах бохир усыг соруулах, -хагуу хог хаягдалаа гэрээний дагуу хугацаандаа ачуулж төлбөрөө төлж байх	Төслийн хүрээнд	Төслийн хүрээнд	15.0 - 200.0	2023	
<b>Нийт дүн</b>				<b>365.000</b>		

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЭЖ БҮЙ “АСФАЛЬТО БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Үйлдвэрлэлийн сул талбайд тухайн орчинд тохирсон ургамал тарих, талбайн 10 хувьд ногоон байгууламж байгуулах	Эвдэгдсэн газрыг тэгшлэж засах, цэцгийн мандал, мод, бут тарих	Үйлдвэрийн орчны газрыг ногоон байгууламжтай болгох	850.0	2023	
<b>Нийт дүн</b>				<b>850.0</b>		

**Мод тарих хялбаршуулсан арга**

Тарималжуулалтад зориулж мод сөөгийг сонгон авах, суулгахад бэлтгэх: Ногоон байгууламж байгуулах нь зарим төрлийн хорт хийн хэмжээг эрс багасгах нөхцөлийг бий болгодог. Судалгаанаас үзэхэд шилмүүст мод хүхэрлэг хийг илүү шингээх чадвартай ба түүний агаар дахь агууламжийг 2 дахин багасгадаг байна. Цэцэрлэгжүүлэлтэд зориулж мод, сөөг, ургамлыг ойгоос болон мод үржүүлгийн газраас шилжүүлэн суулгахдаа юуны өмнө авах модоо сайн шинжиж судлах шаардлагатай (Геоэкологийн хүрээлэн, Мод тарих, ногоон байгууламж байгуулах нь, УБ 2005).

1. Модыг хавар 4 дүгээр сарын 25-наас, 5 дугаар сарын 25 хүртэлх хугацаанд тарих нь хамгийн үр дүнтэй байдаг ажээ.
2. Өөрийн сонгож авсан газраа 50-60см гүн, 70-80см өргөнтэй ухаж бэлтгэнэ.
3. Ухаж бэлтгэсэн нүхэндээ 50 хувь хар шороо, 30 хувь элс, 20 хувь хөх бууц болон бусад бордоог хийнэ.
4. Суулгачыг тарихдаа бэлтгэсэн нүхнийхээ голд үндсийг нь нугалалгүйгээр жигд тарааж, суулгаж өгнө.
5. Суулгасныхаа дараа хөрсийг сайтар нягтаршуулж, гишгэж өгөөд нэг модыг 40-60л усаар усална.
6. Өглөө оройн цагт 30-40л усаар нэг модыг нэгээс хоёр удаа услах бөгөөд, услах хоног нь долоогоос арав хоног. Суулгаснаас хойш арван сард нэг удаа цэнэг усалгааг хийх бөгөөд усалгаа хийх явцдаа хөрсний сийрүүлэлтийг хийж өгдөг байна.
7. Модоо тарьсан цагаас хойш гурван жилийн дараагаас арчилгаа усалгааг хийх шаардлагагүй болдог ажээ.
8. Мод сөөг тарьсны дараа талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө мод сөөгний нүхнээс гарсан хайрга, чулууг зөөж цэвэрлээд, шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30см гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5x2.5 сантиметрийн гишүүрээр гишгиж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20см-ээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно. Үрийг 1м2 талбайд 50-80гр орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармуураар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучна.

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТО БЕТОН ХОЛЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйлдвэрлэлийн сул талбайд тухайн орчинд тохирсон ургамал тарих, талбайн 30 хувьд ногоон байгууламж байгуулах
- Жил бүр ургамлын мониторинг судалгааг явуулах.
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хогийн нэгдэсэн цэг байгуулах, хогийг орчиндоо тархахааргүй байх талаар арга хэмжээ авах.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Бохир усны шугам сүлжээнд гэмтэл гарснаас бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс бохирдох, ургамлан нөмрөг талхлагдаж болзошгүй.	Элэгдэж хуучирсан, удаан хугацаанд ашигласан бохир усны шугам сүлжээг солих, бохир усны шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, засаж сэлбэж байх Төслийн эзлэлбэр газраас бусад талбайн ургамалыг хамгаалахын тулд тогтсон нэг маршрутын дагуу явах /хайрган хучилт байнга хийх/	Төсөл хэрэгжих хугацааны туршид Төслийн талбайд Төслийн эхэнд ба төгсгөлд	500.0 Түрүү жил нөөцөлсөн 100.0	2023 2023 2023	□MNS 5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулагт, хадгалагт □MNS 6138:2010 Мод үржүүлгийн талбай сонгох арга. Техникийн шаардлага □MNS 6140:2010 Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага □MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
<b>Нийт дүн</b>			<b>600.0</b>		

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТО БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Асфальто бетон хольцын үйлдвэр” төсөл нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS 18000 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах нь зүйтэй. Гэнэтийн ослын эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг доорх харуулав.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах аргачлал	стандарт,
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, гальн гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах /техникийн дэвтэр хөтлөх, дээжний дэвтэр хөтлөлт/ хийх	Төсөл хэрэгжих хугацааны туршид	300.0	2023		
2	Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Байгалийн гамшигын үед авч хэрэгжүүлж болох бүхий л арга хэмжээг авах Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төсөл хэрэгжих хугацааны туршид Төсөл хэрэгжих хугацааны туршид	250.0 450.0	2023 2023	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1	
3		Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил,маск) хангах	Төсөл хэрэгжих хугацааны туршид	2.000.0	Жил бүр		
6		Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мөргөжлийн байгууллагаар тогтоолох Аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажил эхлэхийн өмнө өдөр бүр өгөх, шаардлагатай хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажиллах	Төсөл хэрэгжих хугацааны туршид Төсөл хэрэгжих хугацааны туршид	150.0 --*--	2023 2023		
				<b>3.150.000</b>			
<b>Нийт дүн</b>							

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “АСФАЛЬТО БЕТОН ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төсөл хэрэгжих талбайд	500.0	2023	Барилгын норм ба дүрм /БНБД/ 30.01.04 “Хог, тосгоны төлөвлөлт, Барилгажилтын норм ба дүрэм” MNS5850-2008,
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг зайлуулж буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих, Ус бохирдуулсаны төлбөр төлөж байх /дээр дурьдсан/	Төсөл хэрэгжих хугацааны туршид	-	2023	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Бохир ус, хаягдал усны стандарт MNS 4943:2015
Хийн хаягдал гарч агаар бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Төсөл хэрэгжих хугацааны туршид	500.0	2023	
<b>Нийт дүн:</b>			<b>1.000.000</b>		

